



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2014.11.10. № 01/9463

танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газрын Ажлын хэсэг 2014 оны 6 дугаар сарын 18-ны өдрөөс 7 дугаар сарын 10-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлагууд, 21 суманд ажилласан.

Ажлын хэсэг ажиллах хугацаандаа аймаг, сумдын иргэд олон нийттэй уулзан санал хүсэлтийг нь сонсож, тэдгээрийн гомдол мэдээллийн мөрөөр ажиллахын зэрэгцээ иргэдэд болон нийтийн албан тушаалтанд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулж, авлигын эсрэг үйл ажиллагааг хариуцдаг эрх бүхий албан тушаалтнуудад төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэсэн мэргэжил арга зүйн туслалцааг үзүүлж байсан болно.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн байдалтай танилцахад дараах нийтлэг зөрчил, дутагдлууд илэрсэн. Тухайлбал,

1. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулаагүй томилсон, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлэх, тайлбар гаргуулах, давхар ажил эрхлэхтэй холбоотой бүртгэл, судалгааг гаргаж хэвшүүлээгүй;

2. тендерийн үнэлгээний хорооны гишүүд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан мэдэгдэл гаргадаггүй;

3. албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтыг зөрчиж хандив зохион байгуулах, бэлэг, санхүүгийн туслалцаа авах явдал нийтлэг хавтгайрсан;

4. Засаг даргын нөөц хөрөнгөөс дасгалжуулагчийн урамшуулал, төсөл хөтөлбөр, чөлөөт амралт, спортын арга хэмжээ, бөхчүүдийн наадмын бэлтгэл, хэлэлцүүлэг, хоолны зардал, тэмдэглэлт ойн арга хэмжээ, замын зардал, гаднаас ирсэн төлөөлөгчдийн буудлын зардал, хүндэтгэл үзүүлэх зэрэг үйл ажиллагааг санхүүжүүлсэн нь Сангийн сайдын 2012

019636

оны №239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг зөрчсөн;

5. аймаг болон сумдын төсөв хөрөнгийг батлах, үнэ тариф тогтоохдоо холбогдох хууль тогтоомжийн хүрээнд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн батлуулалгүй (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид)-ээр тогтоодог;

6. төсөв санхүү, худалдан авах ажиллагаатай холбогдох мэдээлэл иргэд олон нийтэд нээлттэй ил тод биш;

7. сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын хэрэгжилтийн байдалтай танилцахад төслийн талаарх мэдээлэл ил тод бус, сумын удирдлагууд болон төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүд өөрийн хамаарал бүхий этгээдэд зээл олгодог, энэ тохиолдолд гишүүд нь ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдэгдэл гаргадаггүй,

8. зарим сумдын сум хөгжүүлэх сангийн данс нь Төрийн санд тусгай данстай байх шаардлагыг хангаагүй, зээлийн хөрөнгийг өөр үйл ажилагаанд зарцуулдаг, төсөл сонгон шалгаруулахдаа иргэний төлөөллийг оролцуулаагүй, ИТХ-аас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоогоогүй зэрэг болно.

Иймд Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг чанд мөрдөж, дээр дурдсан зөрчил дутагдлыг дахин гаргахгүйгээр ажиллах талаар аймгийн ЗДТГ, эрхлэх асуудлын хүрээний байгууллага, сумын удирдлага, албан тушаалтнуудад чиглэсэн асуудлаар тодорхой арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Зөвлөмж болгож байна.

Дээрх Зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч, дүнг 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

A square official stamp with a double-line border. Inside the stamp, there is a handwritten signature in black ink. The signature is stylized and appears to be 'Н. ГАНБОЛД'. The stamp also contains some faint, illegible text, likely the name of the institution and its address.

Н.ГАНБОЛД